





4th Story

Балтисм хүүртээд сориЛтонд орсон

Into the Wilderness.



Баптисм хүртээд сорилтонд орсон

– 4th Story –

Тэмээ (тэмээний удаан дуу хоолойгоор) ээ халцгай ~~ хэдийг хүртэл энд ингэж байх ёстой юм бол ... энд өдөр бүр яг адилхан зүйлээ л давтаад байх шиг ... маш уйтгартай ... хүмүүс ирээд Иохан гэдэг хүний хий гэснээр усанд ороод гарч ирээд байх юм. Энэ Иохан гэдэг хүн ... жаахан сонин хүн юм шиг байна. Унтахдаа цөлд унтаж, идэхдээ зөгийн балыг бүхэлд нь идэж, өмсөх юм нь тэмээний ноосон хувцас өмсдөг болохоор миний сэтгэл санаа ямар байхав? Би тэмээ ш дээ ... аа, ёстой нээрээ манай удмынхныг ...

Баптист Иохан Би баптисм хүртээхдээ усаар хүртээдэг боловч удахгүй тэнгэрээс Нэг хүн ирнэ л дээ.... би ч Түүний гутлыг ч үдэж чадахааргүй хэмжээний агуу Нэгэн шүү.

Тэмээ Байнга л нөгөөдхөө ярих юм ... би жинхэнээсээ явлаа аа~~ Хөө? Хүмүүс бүр л их цугларах нь?

Баптист Иохан (сэтгэл нь хөдлөн) Энэ хүнийг харагтун~! Энэ хүн бол жирийн Нэгэн биш. Бурханы бяцхан хурга. Миний өнөөдрийг хүртэл хэлж байсан Нэгэн бол энэ Хүн.

Сони Хөөе хөөе ~~ чиний нэр хэн бэ?

Тэмээ Намайг Камелмагиадо, зүгээр Тэмка гэсэн ч болно .. харин чи?

Сони Намайг Окидонки гэдэг.

Тэмээ Ингэхэд тэр тэмээ шиг хувцасласан ахын хэлсэн шиг, чиний мордуулж ирсэн тэр ах гуай тийм онцгой юмуу?

Сони Тэгэлгүй яахав, мэдээж. Бүр түүнээс илүү гээч. Би төрсөн цагаасаа л ахын гэрийнхэнтэй хамт амьдарсан. Үнэхээр онцгой Нэгэн. Манай аав түүнийг төрөх үед хамт байсан, тэр үеэс л янзын байсан.

Тэмээ Нээрээ юү?

Сони Чи одоо итгэж чадахгүй гээд байгаам уу?

Тэмээ Үгүй ээ үгүй ... гэхдээ ... би урьд нь гайхалтай зүйл харж байсан. Тэр бүгд хуурамч байсан. Би зүгээр л ямар нэг чадвартай тийм хүн л гэж бодсон.

Сони хараад мэднэ дээ ~~~~



Есүс Би танаас баптисм хүртэхээр ирлээ.

Баптист Иохан Юу юу гэнээ? Би яаж Танд баптисм хүртээж чадах билээ? Та надад баптисм хүртээж өгөх хэрэгтэй. Тийм биз дээ. Надад баптисм буулгаж өгөөч.

Есүс Иохан аа~!! Одоо надад баптисм хүртээгээрэй. Энэ нь надад үнэхээр чухал зүйл. Тэгээд намайг илгээсэн Нэгэнд ч бас маш чухал явдал. Та заавал хийх ёстой!

Баптист Иохан Аан, ойлголоо. Эзэн минь. Танд болон дээр байдаг Бурханд чухал юм бол, тэгвэл надад ч гэсэн чухал явдал. Хүссэнээр тань болгоё.

Өгүүлэгч Иохан Есүсийн толгойг усанд дүрлээ. Гэтэл яг тэр үед гэнэт тэнгэр цэлийтэл гэрэлтэв. Тэгээд нэг тагтаа хаа нэгтэйгээс бууж ирэв. Тэгээд нэгэн дуу хоолой сонсогдлоо.

Баптист Иохан Хүүе!!

Бурхан Энэ бол Миний хайртай хүн, Би энэ хүнээс үүдэн ихэд баяртай байдаг.

Хүмүүс <айдаст автсан дуугаар> хөөх, яа яанаа ~~~~

Баптист Иохан Эзэн~!! Эзэн минь

Есүс Иохан аа, баярлалаа.

Тэмээ Юу вэ? юу байсан бэ? хүүш ээ...

Сони хүүе хүүе Ариун Сүнс шүү дээ~~~

Тэмээ Тэрийг харсан уу? Тэр дуу хаанаас гарсан бэ? Бурхан минь, Бурхан минь ... тэр тагтаа яг Тэр хүн дээр нисэж очоод Түүний мөрөн дээр суусан ~~

Сони (инээн) би хэлсэн ш дээ. Тэр бол төсөөлснөөс илүү гэж. Тэр бол Бурханы Хүү.

Тэмээ Хөөх ... бүр янзтай ... итгээгүйд уучлаарай. Одоо жинхэнээсээ итгэж чадна.

Сони Гэхдээ би одоо явах хэрэгтэй. Бид хэзээ нэгэн цагт дахин уулзаж чадах байх.

Тэмээ Тийм ээ! баяртай~!~~

Өгүүлэгч Есүс Иоханаас баптисм хүртсэний дараа цөл рүү явав. Ганцаараа очоод юу ч идэлгүй залбирсан юм.

Есүс Баярлалаа. Окидонки. Гэвч одоо би ганцаараа энэ замаар явах хэрэгтэй. Явлаа. Дараа дахиад уулзъя.

40 өдөр өнгөрсөний дараа

Есүс ... Амээн

Сатан Аа ... энэ чулууг хар даа, би чамайг хэн гэдгийг мэднэ ... Есүс ... зүгээр хэлэхэд л тэрийг талх болгож чадна ... за алив чи бас хүсэж байгаа ш дээ...



Есүс үгүй дээ?

Сатан ердөө... ганцхан жижиг чулуу...өлсөж байгаа биз дээ...айн? энэд хэдэн өдөр байсан билээ?40 өдөр? Юу ч идээгүй биз дээ? Айн?

Есүс Библи дээр хүн зөвхөн талхаар бус Бурханы үгээр амьдардаг гэж бичигдсэн байдаг.

Сатан Аа тийм үү? за за ... чи Бурханы хүү шүү дээ... ямар байна? Эндээс үсэрнэ шүү. Би ч гэсэн үгийг бүгдийг мэднэ... би ч мэднэ гэсэн үг. Бурхан тэнгэрэлч нарт тушаах болно ... тэнгэр элч нар хоёр гараараа сайхан хүлээж авна... 100%! төгс! Үсний үзүүрийг ч гэмтээхгүй~ бүү санаа зов~ хоёулаа нэг шалгаад үзье~ тэх үү?

Есүс Библид чи өөрийн Эзэн Бурханаа бүү сорь гэж бичигдсэн байдаг.

Сатан (уураа барьж ядан амьсгал авна) энэ харагдаж байгаа биз? За! Толгойгоо өргө дөө! Чамд харагддаг бүх зүйлийг би үнэхээр найрсагаар аваачиж өгнө. Тиймээс надад зүгээр хальт, ганц удаа мөргөвөл ямар уу? Яахав, түр суугаад босно гэж бодоод хийгээд үз. Бүгдийг өгье! Бүгдийг өгнө!

Есүс Сатан аа~ чи үнэхээр ядаргаатай юм~ Библид өөрийн Эзэн Бурханыг хүндэтгэн мөргөж, үйлчил гэсэн, эндээс зайлагтун~

Сатан ааааа арай ч дээ ~~~~ үнэхээр том саатал, бүр цөмийн саатал. Би ялагдаагүй шүү. Би чамтай арай дуусаагүй шүү.